



MONGOLIAN ACADEMY OF  
SCIENCES

A.Amaryn gudamj 1, Ulaanbaatar 14200,  
PO 20a, Box 34, MONGOLIA  
Tel / Fax: (976-11) 26-22-47, Fax: (976-11) 321993  
E-mail: mas@mas.ac.mn

Date: 20 April 2017  
Ref: 1/159

ЯПОН УЛСЫН  
МОНГОЛ СУДЛАЛЫН ХОЛБООНЫ  
ЕРӨНХИЙЛӨГЧ ПРОФЕССОР  
ХИРОШИ ФУТАКИ ТАНАА

Эмгэнэлийн үг

Токиогийн гадаад судлалын их сургуулийн эмирит профессор, Монгол Улсын Шинжлэх Ухааны Академийн гадаад гишүүн, Олон улсын монгол судлалын холбооны хүндэт ерөнхийлөгч, МУИС-ийн хүндэт профессор, Японы монголч эрдэмтний нийгэмлэгийн хүндэт ерөнхийлөгч, хэл бичгийн ухааны доктор, профессор Шигэо ОЗАВА 2017 оны 3 сарын 12-ны өдөр тэнгэрт хальсныг сонсоод Монгол Улсын Шинжлэх Ухааны Академийн Тэргүүлэгчид туйлаар харамсан, гүн эмгэнэл илэрхийлж байна.

Талийгаач Шигэо ОЗАВА профессор бол “Монголын нууц товчоон”-ы судлалд өөрийн бүхий л бүтээлч амьдрал, шавхагдашгүй агуу хүч-хөдөлмөр, хичээл зүтгэлээ бүрэн зориулсан хийгээд дэлхийн Монгол судлалын хөгжилд балрашгүй ул мөрөө үлдээсэн Их эрдэмтэн билээ.

Профессор Ш.Озава 1990 оны VIII сард Олон Улсын Монгол Судлалын Холбоонны Ерөнхийлөгчийн үүрэг гүйцэтгэгч, 1992 оны VIII сард ОУМСХ-ны Ерөнхийлөгчөөр сонгогдож, 2011 оны зун хүртэл он удаан жил үр бүтээлтэй ажиллаж, дэлхийн Монгол судлалыг хөгжүүлэхэд өөрийн оюун ухаан, зүрх сэтгэлээ зориулж ирснийг бид бахархан санаж, хүндэтгэн дурсах болно.

Эдүгээ бид Монгол Улсын Шинжлэх Ухааны Академийн Тэргүүлэгчдийн нэрийн өмнөөс болон хувиасаа нэрт монгол судлаач, доктор, профессор Ш.Озава нас барсанд гүнээ эмгэнэн гашуудаж талийгаачийн ар гэр, төрөл садан, хамт олон, шавь нарт нь гүн эмгэнэл илэрхийлж байгааг минь хүлээн авна уу.

*Мэхийн хүндэтгэсэн,*

ЕРӨНХИЙЛӨГЧ, АКАДЕМИЧ



Д.РЭГДЭЛ

200000706

## モンゴル科学アカデミー

2017年4月20日

日本モンゴル学会会長  
二木博史教授殿

### 弔詞

東京外国語大学名誉教授、モンゴル科学アカデミー外国人会員、国際モンゴル学会名誉会長、モンゴル国立大学名誉教授、日本モンゴル学会名誉会長、文学博士の小澤重男教授が2017年3月21日に逝去されたという報に接し、モンゴル科学アカデミー評議会は心から哀悼の意を表するものであります。

故小澤重男教授は『モンゴル秘史』の研究にその生涯をささげ、世界のモンゴル研究の発展に偉大な足跡をのこした大学者です。

小澤重男教授は1990年8月に国際モンゴル学会会長代行に選ばれたあと、1992年8月に正式な会長に選出され、2011年夏まで長期にわたりその任にあたり、世界のモンゴル研究の発展のために尽力されました。わたしたちはこのことを尊敬の念をもって記憶していくことでしょう。

わたくしはモンゴル科学アカデミー評議会を代表して、またわたくし個人として、高名なモンゴル学者、文学博士、小澤重男教授の逝去に対し弔意をあらわすとともに、故人のご家族、ご親戚、同僚、弟子のみなさまに対して哀悼の意を表するものです。

モンゴル科学アカデミー総裁  
D.レグデル (D. Regdel)